



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/002/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот	2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaaq@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: М.Атарцэцэг Утас: 88984411 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn Аудитор: Б.Мөнхболд Утас: 99041008 Цахим хаяг: munkhboldbo@audit.gov.mn
--	---------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ДАРГА Л.ЭНХЖАРГАЛ ТАНАА

2025.03.31

№

135

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Нийгмийн даатгалын багц хууль 2023 онд шинэчлэн батлагдаж, 2024 оны 01 дүгээр сараас эхлэн хэрэгжүүлсэн.

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2024 оноос бүртгэл мэдээллийн шинэ системийг нэвтрүүлэн хэрэгжүүлсэн.

Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 15 дугаар тогтоолоор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийг Нийгмийн даатгалын газар болгон өөрчилсөн байна.

Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар 04 дүгээр сарын 01-ний өдрөөс нийт тэтгэвэр авагчдын тэтгэврийг 100.0 мянган төгрөгөөр, бүрэн

8225020391

тэтгэврийн доод хэмжээ 650.0 мянган төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 540.0 мянган төгрөгөөр нэмэх шийдвэр гарсан байна.

Аудитын гол асуудал

Аймгийн хэмжээнд 9500 тэтгэвэр авагчийн тэтгэврийг нэмэгдүүлэн олгосон байна.

Засгийн газрын 128 дугаар тогтоолоор "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг" шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор нийгмийн даатгалын санд төлөх шимтгэлийн орлогын хэмжээ нэмэгдсэн байна.

Тайлант онд нийгмийн даатгалын санд 125,249,937.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 124,071.545.3 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг даатгуулагчид олгожээ.

Бусад асуудал

Тус байгууллага нь тайлант онд 4 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, Нийгмийн даатгалын ерөнхий газраас 91.2 хувьтай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ТҮНЖИДМАА

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт

Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	9,734,424,129.55	11,047,414,485.35
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,028,512,665.70	7,206,905,149.13
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	6,028,512,665.70	7,206,905,149.13
31210	Төгрөг	6,028,512,665.70	7,206,905,149.13
31211	Төрийн сангийн харилцах	3,867,011.70	0
31213	Арилжааны банк дахь харилцах	6,024,645,654.00	7,206,905,149.13
33	АВЛАГА	3,705,911,463.85	3,840,509,336.22
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0	0
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	2,596,596,871.39	0
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1,092,238,904.49	1,091,852,804.49
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	0	2,692,155,758.98
33500	Бусад авлага	17,075,687.97	56,500,772.75
33510	Байгууллагаас авах авлага	17,075,687.97	4,379,366.05
33520	Хувь хүмүүсээс авах авлага	0	52,121,406.70
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	9,734,424,129.55	11,047,414,485.35
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	305,053,904.62	1,171,508,920.56
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	305,053,904.62	1,171,508,920.56
41100	Богино хугацаат үнэт цаас	0	0
41300	Өглөг	13,609,858.32	453,802,480.48
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	13,609,858.32	0
41360	Бусад өглөг	0	453,802,480.48
41361	Байгууллагад төлөх өглөг	0	29,188,004.44
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0	424,345,224.53
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	0	269,251.51
41400	Урьдчилж орсон орлого	291,444,046.30	717,706,440.08
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	291,444,046.30	717,706,440.08
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,429,370,224.93	9,875,905,564.79
51	Засгийн газрын хувь оролцоо	9,429,370,224.93	9,875,905,564.79
51200	Хуримтлагдсан үр дүн	9,429,370,224.93	9,875,905,564.79
51210	Өмнөх үеийн үр дүн	9,256,418,550.41	9,087,636,584.98
51220	Тайлант үеийн үр дүн	172,951,674.52	788,268,979.81
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	9,734,424,129.55	11,047,414,485.35

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	130,159,405,983.33	118,640,809,660.28
11	ТАТВАРЫН ОРЛОГО	30,675,944,740.42	34,926,863,359.54
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	30,675,944,740.42	34,926,863,359.54
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	21,272,250,794.97	29,504,892,919.53
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,222,383,553.68	3,079,910,996.13
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,345,328,267.12	1,316,621,864.87
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	420,789,959.29	1,025,437,579.01
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	5,415,192,165.36	0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	55,560,816.79	82,453,419.18
120	Нийтлэг татварын бус орлого	55,560,816.79	82,453,419.18
120001	Хувьцааны ногдол ашиг	0	0
120002	Хүүгийн орлого	25,341,111.12	31,989,072.34
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,701,352.67	0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,701,352.67	0
120009	Бусад орлого	21,518,353.00	50,464,346.84
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	99,427,900,426.12	83,631,492,881.56
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,534,437,895.00	15,695,181,391.56
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,534,437,895.00	15,695,181,391.56
1330	Төсвийн захирагчдаас	91,893,462,531.12	67,936,311,490.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	91,893,462,531.12	67,936,311,490.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	129,986,454,308.81	117,852,540,680.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	129,986,454,308.81	117,852,540,680.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,501,470.00	12,462,420.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,501,470.00	12,462,420.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0	7,010,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,501,470.00	5,452,420.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	129,981,952,838.81	117,840,078,260.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	65,294,868,652.00	83,507,179,239.74
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	65,294,868,652.00	83,507,179,239.74
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	64,687,084,186.81	34,332,899,020.73
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	64,687,084,186.81	34,332,899,020.73
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	172,951,674.52	788,268,979.81
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	172,951,674.52	788,268,979.81



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	131,378,639,181.13	125,249,937,829.26
11	ТАТВАРЫН ОРЛОГО	30,282,841,415.73	41,761,608,519.16
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	30,282,841,415.73	41,761,608,519.16
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	20,991,996,034.09	29,807,035,389.08
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,192,331,989.27	3,047,701,926.17
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,324,801,566.16	1,416,105,670.45
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	413,588,435.20	1,024,056,460.40
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	5,360,123,391.01	6,466,709,073.06
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	61,974,534.28	72,822,520.10
120	Нийтлэг татварын бус орлого	61,974,534.28	72,822,520.10
120001	Хувьцааны ногдол ашиг	0	0
120002	Хүүгийн орлого	20,850,751.15	32,023,120.89
120003	Торгуулийн орлого	0	0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	41,123,783.13	0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	41,123,783.13	0
120009	Бусад орлого	0	40,799,399.21
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	101,033,823,231.12	83,415,506,790.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	9,140,360,700.00	15,479,195,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	9,140,360,700.00	15,479,195,300.00
1330	Төсвийн захирагчдаас	91,893,462,531.12	67,936,311,490.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	0
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	91,893,462,531.12	67,936,311,490.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	130,094,006,278.22	124,071,545,345.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	130,094,006,278.22	124,071,545,345.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,501,470.00	47,514,369.42
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,501,470.00	12,462,420.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	7,010,000.00

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,501,470.00	5,452,420.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	35,051,949.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	35,051,949.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	130,089,504,808.22	124,024,030,976.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	65,402,420,621.41	83,064,681,934.11
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	65,291,799,123.92	83,064,681,934.11
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	110,621,497.49	0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	64,687,084,186.81	40,959,349,042.30
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	64,687,084,186.81	40,959,349,042.30
213504	Хөрөнгийн	0.00	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,284,632,902.91	1,178,392,483.43
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,284,632,902.91	1,178,392,483.43
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,743,879,762.79	6,028,512,665.70
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,028,512,665.70	7,206,905,149.13

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,266,704,972.34	9,266,704,972.34
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(10,286,421.93)	(10,286,421.93)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,256,418,550.41	9,256,418,550.41
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	172,951,674.52	172,951,674.52
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,429,370,224.93	9,429,370,224.93
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	9,429,370,224.93	9,429,370,224.93
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(341,733,639.95)	(341,733,639.95)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,087,636,584.98	9,087,636,584.98
19	Тайлант үеийн үр дүн	788,268,979.81	788,268,979.81
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	9,875,905,564.79	9,875,905,564.79



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан


(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	85,818,549,000.00	83,077,144,354.11	2,741,404,645.89	96.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	85,818,549,000.00	83,077,144,354.11	2,741,404,645.89	96.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,205,400.00	12,462,420.00	2,742,980.00	82.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,205,400.00	12,462,420.00	2,742,980.00	82.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,903,300.00	7,010,000.00	893,300.00	88.7
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	7,302,100.00	5,452,420.00	1,849,680.00	74.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	85,803,343,600.00	83,064,681,934.11	2,738,661,665.89	96.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	85,803,343,600.00	83,064,681,934.11	2,738,661,665.89	96.8
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	85,803,343,600.00	83,064,681,934.11	2,738,661,665.89	96.8
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	85,818,549,000.00	50,840,781,536.44	34,977,767,463.56	59.2
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	15,479,195,300.00	15,479,195,300.00	0.00	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	15,479,195,300.00	15,479,195,300.00	0.00	100.0
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	70,339,353,700.00	35,361,586,236.44	34,977,767,463.56	50.3
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	70,339,353,700.00	35,361,586,236.44	34,977,767,463.56	50.3
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	6,028,512,665.70	(6,028,512,665.70)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	7,206,905,149.13	(7,206,905,149.13)	

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар алдаа, зөрчил илрээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгарлагдтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
	НИЙТ		1			1			

